

Маягт нөхөх товч заавар:

Объектын өмчийн төрөл (5-р багана)-д барилгын захиалагч улсын байгууллага-1, хувийн- 2 гэсэн тоог нөхнө.

Объектын регистр, объектын өмчийн төрлийг тухайн аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд мэдээг дамжуулахдаа бөглөнө. Объектын гүйцэтгэгч болон захиалагч солигдоход объектын регистр өөрчлөгдөхгүй, нэг объект баригдах хугацааныхаа туршид нэг регистртэй байхыг анхаарна уу!

Барилгын төрөл (6-р багана) нь дотроо 3 бүлэгт хуваагдах бөгөөд

Орон сууцны барилгын хувьд

| | | | | | | | |
|----------|---|--------------------------------|----|---------------------------|----|----------------------------------|----|
| угсармал | 2 | Орон сууцны бус барилгын хувьд | | Инженерийн барилгын хувьд | | Их засварын ажлын хувьд | |
| тоосгон | 3 | үйлдвэрийн зориулалттай | 6 | эрчим хүчний | 14 | орон сууцны | 22 |
| блокон | 4 | худалдаа үйлчилгээний | 7 | холбооны | 15 | орон сууцны бус | 23 |
| бусад | 5 | зочид буудал | 8 | төмөр зам | 16 | инженерийн барилга | 24 |
| | | эмнэлэг | 9 | авто зам | 17 | гэсэн тоонуудыг тус тус бөглөнө. | |
| | | сүм хийд | 10 | гүүр, гүүрэн гарц | 18 | | |
| | | сургууль соёлын | 11 | далан, суваг, шугам | 19 | | |
| | | конторын зориулалтай | 12 | бусад зам талбай | 20 | | |
| | | агуулах гарааж-н зориулалттай | 13 | | | | |

Барилгын зориулалт (7-р багана)-д шинэ болон өргөтгөл шинэчлэл бол 1, их засвар бол 21 гэсэн тоог нөхнө.

Хүчин чадлын биет хэмжээг орон сууцны барилгын хувьд хаалгаар буюу айлаар, орон сууцны бус үйлдвэрийн барилга, худалдаа, үйлчилгээний барилгыг м²-аар, зочид буудал, эмнэлгийн барилгын хувьд ороор, сургууль, соёлын барилгыг суудлаар, контор (албан тасалгааны) зориулалттай барилгын хувьд м²-аар, гаражийг машины тоогоор, инженерийн барилга байгууламжийн хувьд эрчим хүчний барилга, объектыг кВт-аар, холбооны барилгыг м²-аар, төмөр замыг төмөр замын уртаар буюу м-ээр, харин төмөр замын орон сууцны барилгыг айлаар, албан конторын зориулалттай бол м²-аар гэх мэтчилэн холбогдох төрөлд нь оруулна, замын уртыг км-ээр, замд хийсэн нөхөөсийг м²-аар, гүүрийг м-ээр, далан, сувгийг м-ээр, шугам, сүлжээг кВт, км-ээр тус тус бөглөнө.

Багана 10-д тухайн объектын төсөвт өртгийг (үнийн зөрүү болон бусад өөрчлөлтийг тусгасан байдлаар) нөхнө. **Барилгын нийт талбайг** барилгын зурагт заасан байдлаар (ханын дотор талын урт ба өргөний үржвэрийн нийлбэрээр) нөхнө.

Тайлант оны гүйцэтгэл буюу 12-р баганад тайлант хугацааны гүйцэтгэлийг жилийн эхнээс өссөн дүнгээр бөглөнө.